

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2018 ОНЫ 4 ДҮГЭЭР ХУРАЛДААН**

Хуралдаан 2018 оны гуравдугаар сарын 21-ний 16 цаг 10 минутад эхэлж, 17 цаг 35 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын даргын өрөөнд болж, нийт 1 цаг 25 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	Сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарын сонгон шалгаруулалтын дүнгийн тухай	Цагаандэлгэр сумын сургуулийн захирлын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Адъяа овогтой Мөнхбаатар 71,07 оноогоор тэнцэж, тухайн ажлын байранд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хамгийн илүү хангасан тул тухайн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэхийг Боловсрол, соёл, урлагийн газарт зөвшөөрсөн тогтоол гаргахаар болов.
2	Дэлгэрцогт сумын Засаг даргын Тамгын газрын дарга, Дэлгэрцогт, Дэрэн сумын Эрүүл мэндийн төвийн дарга, Дэрэн сумын Мал эмнэлэг, үржлийн тасгийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын дүнгийн тухай	Дэлгэрцогт сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Сугир овогтой Нарантунгалаг 70,2 оноогоор тэнцэж, тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан тул төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцийн жагсаалтад бүртгэж, тухайн албан тушаалд нь нэр дэвшүүлэхээр болов.
3	Сайнцагаан сумын Санхүү төрийн сангийн тасгийн даргын сонгон шалгаруулалтын дүнгийн тухай	Сонгон шалгаруулалтад хүн тэнцээгүй тул дахин 7 хоногийн дараа зохион байгуулахаар шийдвэрлэв.
4	Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн даргын сонгон шалгаруулалтын дүнгийн тухай	Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшүүлж буй Батбүрэн овогтой Саруулцэцэгийн дүгнэлтийг баталж, тухайн албан тушаал томилуулах санал дүгнэлтийг ЭМГ-т хүргүүлэхээр шийдвэрлэв.
5	Цагдаагийн газрын Захиргааны удирдлагын хэлтсийн дарга, цагдаагин дэ хурандаа Л.Баярсайханыг “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдэгээр шагнуулах тухай	Төрийн тусгай албанд олон жил идэвх санаачилгатай, үр бүтээлтэй ажиллаж, орон нутагт төр засгийн бодлого шийдвэр, төрийн албаны шинэтгэлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж, үр дүн гаргаж байгаа аймгийн Цагдаагийн газрын Захиргааны удирдлагын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Лувсанням овогтой Баярсайханыг “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шагнуулахаар Төрийн албаны зөвлөлд уламжлахаар шийдвэрлэв.
6	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөөцийн зард зарлуулах тухай	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын дэс түшмэлийн 4, туслах түшмэлийн 17 нийт 21 сул орон тоог нөөцийн зард зарлуулахаар шийдэрлэж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхээр болов.
7	Төрийн албаны салбар зөвлөлийн 2018 оны ажлын төлөвлөгөөний төсөл хэлэлцэх	Төрийн албаны салбар зөвлөлийн 2018 оны ажлын төлөвлөгөөн гишүүдээс гаргасан саналыг нэмээд батлав.

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА